САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр Дугаар 95 Улаанбаатар хот

"Миг даатгал" ХХК -ийн дүрмийн сангийн бүтэц хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 , Хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам"-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Миг даатгал" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Д.Зоригт нь эзэмшиж буй 122,500 ширхэг хувьцааны 87,500 ширхэгийг хувьцаа эзэмшигч Б.Түвшинд, 35,000 ширхэгийг тус даатгалын компанид худалдах болгосонтой холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлэн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт бүртгүүлж, Хороонд ирүүлэхийг "Миг даатгал" ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД